

УЛСЫН ГАЗАР ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ЕРӨНХИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ 2021 ОНЫ ХЭРЭГЖИЛТИЙН ТАЙЛАНГИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

НЭГ. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 384 дүгээр тогтоолоор “Улсын газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө”-г баталж, хэрэгжилтийн явц, үр дүнг жил бүрийн 1 дүгээр улиралд багтаан Засгийн газарт танилцуулж байх”-ыг Барилга, хот байгуулалтын Сайдад даалгасны дагуу уг төлөвлөгөөний 2021 оны хэрэгжилтийн тайланг нэгтгэн дүгнэж, цаашид авах арга хэмжээний саналыг боловсруулав.

ХОЁР. ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

Улсын газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө нь нийт 11 зорилтын хүрээнд 98 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн.

БОАЖЯ, ХХААХҮЯ, ЭХЯ, ГХЯ, БХБЯ, ЗТХЯ, УУХҮЯ, ЦХХХЯ, СоЯ, БСШУЯ, ЭМЯ болон Алтанбулаг, Цагааннуур, Замын-Үүд чөлөөт бүсийн захирагчийн ажлын алба, Усны газар, 21 аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газраас ирүүлсэн тайланг нэгтгэн, зорилт, арга хэмжээний хэрэгжилтийг тооцож үнэлсэн.

ГУРАВ. ХЭРЭГЖИЛТИЙН ЯВЦ

1. Газрын нөөц, нэгдмэл сангийн удирдлага, бодлого, төлөвлөлт, хууль, эрх зүйн орчныг боловсронгуй болгох зорилтын хэрэгжилт

1.1. Газрын харилцааны эрх зүйн шинэчлэл хийх ажлын хүрээнд Газрын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл, Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл, Кадастрын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл, Газрын төлбөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл, Нийгмийн зайлшгүй хэрэгцээнд зориулан газар чөлөөлөх тухай анхдагч хуулийн төслийг тус тус боловсруулж, Засгийн газрын хуралдаанд хэлэлцүүлэхэд бэлтгээд байна.

1.2. Барилга, хот байгуулалтын сайдын 2021 оны 127 дугаар тушаалаар Орон зайн өгөгдлийн дэд бүтцийн тухай хуулийн төслийг шинээр боловсруулах үүрэг бүхий ажлыг хэсгийг байгуулан ажиллаж байна.

1.3. Газар зохион байгуулалт, хот төлөвлөлтийн цахим систем, газрын төлөв байдал, чанарын хяналт, газрын бирж, газрын үнэлгээ, төлбөр, татвар хураамж, газрын кадастрын бүртгэлийг цахимд шилжүүлэх, газрын харилцаатай холбоотой төрийн үйлчилгээг иргэд, олон нийтэд цаг хугацаа, орон зай хамаарахгүй үзүүлэх боломжийг бүрдүүлж, 4 төрлийн цахим системийг үйл ажиллагаанд орууллаа. Үүнд:

- Газар зохион байгуулалт, хот төлөвлөлтийн цахим систем
- Газрын төлөв байдал, чанарын мониторингийн цахим систем
- Газрын кадастрын нэгдсэн систем
- Хаягийн мэдээллийн нэгдсэн систем

1.4. Улсын газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөтэй нийцүүлэн аймгийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөг шинэчлэн боловсруулах арга хэмжээний хувьд 8 аймгийн төлөвлөгөөг шинэчилсэн, 9 төлөвлөгөөг шинэчилж байгаа бол Архангай, Говь-Алтай, Ховд аймгийн төлөвлөгөөг шинэчлэн боловсруулах шаардлагатай байна. Мөн нийт 330 сумаас 91 сумын нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөөг боловсруулж дууссан бөгөөд 248 сумын нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөөг шинээр боловсруулах шаардлагатай байна.

1.5. “Орон зайн мэдээллийн суурь 18 өгөгдлийн сангийн бүтэц, техникийн шаардлага” MNS 6925 1-18:2021 стандартыг СХЗГ-ын даргын 2021 оны С/36 тоот тушаалаар батлууллаа.

1.6. 2021 онд газрын харилцаатай холбоотой 25 журам, зааврыг Засгийн газрын тогтоол, Барилга, хот байгуулалтын Сайдын тушаал, Газар зохион байгуулалт, геодези зураг зүйн газрын даргын тушаалаар батлан мөрдүүлж байна.

1.7. 2020 онд “Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль” батлагдсантай холбогдуулан төрөөс аливаа салбарын бодлого хөтөлбөрийг тусгайлан батлах боломжгүй болсон тул Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газрын стратеги төлөвлөгөөг 2021-2024 он хүртэл хэрэгжүүлэхээр боловсруулан, Барилга хот байгуулалтын Сайдаар 2021 оны 02 дугаар сарын 09-ний өдөр батлуулан, хэрэгжүүлэн ажиллаж байна.

2. Хүн амыг баталгаат, эрүүл аюулгүй усаар хангах зорилтын хэрэгжилт

2.1. 2021 оны байдлаар улсын хэмжээнд гол мөрний урсац бүрэлдэх эхийн 49.91% буюу 7194.5 га талбайг хамгаалалтад аваад байна. Гол, мөрний урсац бүрэлдэх эх, усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий газарт ашигт малтмал хайх, ашиглахыг хориглох тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1-т заасны дагуу гол, мөрний урсац бүрэлдэх эх орчмын газартай ашиглалтын 33 лицензийн 9311 га талбай, хайгуулын 9 лицензийн 5628 га талбай давхцалтай байгаа тул үүнийг шийдвэрлэх шаардлагатай байна.

2.2. Тайширын усан цахилгаан станцаас Говь-Алтай аймгийн төв Алтай хот хүртэлх усан хангамжийн шугам хоолойн барилгын ажил 2021 онд дуусаж ашиглалтад хүлээлгэн өгсөн.

2.3. Багануур дүүрэг, Замын-Үүд, Ханбогд, Цогтцэций сумын төвийн ус хангамжийн шугам сүлжээг сайжруулах, өргөтгөх ажил хийгдсэн бол хилийн 10 цэргийн ангид худаг гаргах, Замын-Үүд, Цагаан хад, Гашуунсухайтын боомтод ус зөөлрүүлэх төхөөрөмжийг суурилуулсан байна. Увс аймгийн Бөхмөрөн сум, Наранбулаг сум, Хэнтий аймгийн Батноров сум, Баянхонгор аймгийн Өлзийт сум, Галуут сум, Эрдэнэцогт сум, Өвөрхангай аймгийн Хайрхандулаан сум, Хужирт сум, Дундговь аймгийн Эрдэнэдалай зэрэг 9 суманд бага оврын цэвэрлэх байгууламжийг ашиглалтад орууллаа.

2.4. Ховд аймгийн 16 сумын 46 баг, Өвөрхангай аймгийн Хайрхандулаан суманд усны хайгуул судалгаа хийсэн.

3. Хөдөө аж ахуйн салбарыг хэрэгцээт усаар хангах зорилтын хэрэгжилт

Бэлчээрийн усан хангамжийг сайжруулах зорилгоор 11 аймгийн 68 сумын 292 байршилд хайгуулын судалгаа, Өмнөговь аймгийн 6 байршилд хөв цөөрмийн судалгаа хийсэн.

2021 онд улсын хэмжээнд 466 инженерийн хийцтэй худаг, 189 гар худаг ашиглалтад оруулж, 850.2 мян.га бэлчээрийг усжуулсан бол Өвөрхангай аймагт 1 хөв барьж ашиглалтад оруулсан.

Эрчимжсэн фермерийн аж ахуйг усаар хангах зорилгоор Дархан-уул аймагт гүн өрмийн 1 худаг, Улаанбаатар хот орчимд 5 худаг шинээр гаргаж, Дархан хотод 1 худгийг сэргээн засварласан. Нийслэлийн Багануур, Багахангай, Баянзүрх дүүргийн усны хайгуул хийж, шинээр инженерийн хийцтэй 3 худаг гаргасан.

Ховд аймгийн Зэрэг, Булган, Үенч, Буянт сумдын 4 усалтын системийг шинээр барьж, сэргээн засварлан усалгаатай тариалангийн талбайг 767 га-аар нэмэгдүүлж, 3031 га талбайг хамарсан 10 усалтын системийг сэргээн засварлах ажлыг эхэлсэн байна.

4. Үйлдвэр, уул уурхай, эрчим хүчний салбарыг хэрэгцээт усаар хангах зорилтын хэрэгжилт

Зорилтын хүрээнд нийт 8 арга хэмжээ 2019-2024 онд хэрэгжихээр төлөвлөснөөс 1 арга хэмжээ 100%, 3 арга хэмжээ 80-90%, 3 арга хэмжээ 50-65%, 1 арга хэмжээ 10%- ийн хэрэгжилттэй байна.

4.1. Өмнийн говийн уул уурхай, хүнд үйлдвэрийн бүсийн усны эрэлт хангамжийн гидроэкономик судалгаа, шинжилгээний ажлыг хийж, Тавантолгой, Оюутолгойн бүсийн ус хангамжийн өнөөгийн байдал, усны эрэлтийг 2030, 2040, 2050 оны түвшинд тодорхойлж, усны эрэлтийг хангах боломжит шийдлийг гаргаж, Говийн бүсийн үйлдвэр, уурхайн ус хангамжийг нэмэгдүүлэх төслийн ТЭЗҮ-ийг боловсруулж Усны газарт хүргүүлээд байна.

4.2. Дорноговь аймгийн Мандах сумын нутагт орших Цагаан цавын газрын доорх усны ордоос Зэсийн баяжмал боловсруулах үйлдвэрт шаардагдах усыг, Бор хөөврийн говийн газрын доорх усны ордоос Дорноговь аймгийн Алтанширээ сумын нутагт байгуулах Газрын тос боловсруулах үйлдвэрт шаардагдах усыг хангахаар шийдвэрлэж 39.4 км урт шугам хоолойн барилга угсралтын ажил эхлүүлсэн. Төлөвлөж буй үйлдвэр уурхайн ус хангамжийн хэрэгцээг Бор хөөвөр, Долоод, Сайн Ус, Цагаан цавын гүний усны ордоос хангахаар төлөвлөж байна.

4.3. Улаанбаатар хотод үйл ажиллагаа явуулж буй 11 арьс ширний үйлдвэрүүдэд бага оврын урьдчилан цэвэрлэх байгууламж нэвтрүүлэх ажил зохион байгуулсан. Азийн хөгжлийн банкны хөрөнгөөр ХБ-ны зээлээр Архангай, Булган, Хөвсгөл, Өвөрхангай, Хэнтий, Өмнөговь, Дундговь, Дорноговь, Сүхбаатар, Дархан-Уул аймгийн төвд бохир ус цэвэрлэх байгууламжийг шинээр барьж ашиглалтад орууллаа.

4.4. 2020 онд Өмнийн говийн уул уурхай, хүнд үйлдвэрийн бүсийн усны эрэлт хангамжийн гидроэкономик судалгаа, шинжилгээний ажлыг хийж, Тавантолгой, Оюутолгойн бүсийн ус хангамжийн өнөөгийн байдал, усны эрэлтийг 2030, 2040, 2050 оны түвшинд тодорхойлж, усны эрэлтийг хангах боломжит шийдлийг гаргасан. 2021 оны 5 сард ТЭЗҮ-ийг Усны газарт хүргүүлээд байна.

4.5. Таван толгойн нүүрсний бүлэг ордыг түшиглэн байгуулагдах үйлдвэрүүдэд шаардлагатай усны хэрэгцээг Дорноговь аймгийн Мандах сумын нутагт орших Цагаан цавын газрын доорх усны ордоос хангах зураг төсөл, байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ хийхэд шаардлагатай 1.7 тэрбум төгрөгийн зардлыг “Эрдэнэс Таван толгой” ХК-ны 2022 оны төсөвт тусгасан.

Дараах 8 үйлдвэрийн газрын доорх усны хайгуул хийгдэж, нөөцийг баталсан байна.

- Хэнтий аймгийн Дархан сумын Бор Өндөрийн баяжуулах үйлдвэр
- Дорноговь аймгийн Өргөн сумын нутагт байгуулах нүүрс баяжуулах үйлдвэр
- Дорноговь аймгийн Даланжаргалан сумын нутагт Хөх цавын цемент болон бетон хийцийн үйлдвэр
- Дорноговь аймгийн Хатанбулаг сумын нутагт орших “Тэнэгэр говь транс” ХХК-ийн нүүрс баяжуулах үйлдвэр
- Дундговь аймгийн Гурвансайхан сумын нутаг дахь “Эрдэнэс силвер ресурс” ХХК-ийн Салхитын мөнгөний ордын баяжуулах үйлдвэр
- Дорнод аймгийн Матад сумын нутаг дахь “Спек” ХХК-ийн Хөх толгойн хайлуур жоншны ордын баяжуулах үйлдвэр

- Говь-Алтай аймгийн Тайшир сумын нутагт орших “Дөрвөлжин” нэртэй шохойн чулууны ордын түүхий шохой, цементийн үйлдвэр

4.6. Дотоодын урсгалтай голуудад усан болон усан цэнэгт цахилгаан станц барих урьдчилсан судалгааны ажлыг хийж, Хэрлэн голд 3, Ерөө голд 1, Орхон гол 1 байршлыг тус тус тодорхойлсон.

Шинээр ашиглалтад орох уул уурхайн болон шинээр байгуулах аж үйлдвэрийн цогцолборуудын усан хангамжийн асуудлыг шийдвэрлэх, одоо байгаа болон шинээр байгуулагдах дулааны цахилгаан станцын ус хангамжийн асуудлыг шийдвэрлэх зэрэг арга хэмжээ 10-50% ийн хэрэгжилттэй байна.

5.Хүрээлэн буй орчны тэнцвэрт байдлыг хангах, усны нөөцийг хамгаалах зорилтын хэрэгжилт

Зорилтын хүрээнд нийт 8 арга хэмжээ 2019-2021 онд хэрэгжихээр төлөвлөснөөс 4 арга хэмжээ 50%, 2 арга хэмжээ 10-30%, 2 арга хэмжээ 20%-ийн хэрэгжилттэй байна.

5.1. Улсын хэмжээнд гол мөрний урсац бүрэлдэх эхийн нийт талбайн 49.91% буюу 7194 га талбайг улсын тусгай хамгаалалтад аваад байна.

5.2. Говийн баянбүрдийн нэгдсэн тооллого, зураглал хийж гүйцэтгэх, түүнийг хамгаалах, зүй зохистой ашиглах ажлын хүрээнд Усны тухай хуулийн дагуу сав газрын захиргаа, орон нутгийн мэргэжлийн байгууллагатай хамтран усны сан бүхий газрын тооллогыг жил бүр хийж дүн мэдээг нэгтгэж байгаа бөгөөд улсын хэмжээнд 35 баянбүрд тоологдоод байна.

5.3. Монгол оронд гадаргын усны хуримтлал бий болгох, урсацын тохируулга хийх замаар усны нөөцийг нэмэгдүүлэх “Хөх морь” төслийн үйл ажиллагааны хүрээнд 12 голын 33 хөндлүүр буюу боомт барьж, усан сан байгуулах боломжтой газрын байршлыг сонгон, гадаргын усыг хуримтлуулах боломжийг судалсан.

5.4.Өвөрхангай аймгийн 3 сум, Баянхонгор аймгийн төвийн шинэ суурьшлийн бүс, Баян-Өлгий аймгийн 89 айл өрхийг төвлөрсөн ус хангамж, ариутгах татуургын шугам сүлжээнд холбосон.

Энэ зорилтын хүрээнд Хот, суурины эзэмшил газарт хамаарах голын эргийг тохижуулах, Рамсарын Конвенцийн хэрэгжилтийг хангах, гэрээнд хамрагдах ус намгархаг газрын тоог нэмэгдүүлэх, хот, суурин газрын ногоон байгууламжийн усалгааны арга технологид шинэчлэлт хийж, усалгааны горимыг мөрдүүлэх, бохирдсон голуудын гольдролд үзлэг хийж, нөхөн сэргээх зэрэг ажлуудын хэрэгжилт 10-30%-тай байна.

6.Хөдөө аж ахуйн салбарыг хөгжүүлэх зорилтын хэрэгжилт

Зорилтын хүрээнд нийт 7 арга хэмжээ 2020-2025 онд хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 1 арга хэмжээ 50%, 2 арга хэмжээ 23-35%, 4 арга хэмжээ 0-12%-ийн хэрэгжилттэй байна.

6.1. Засгийн газрын 2018 оны 131 дүгээр тогтоолоор улсын хэмжээнд газар тариалангийн бүс нутгийг 11 аймгийн 60 сумын 160 багаар тогтоосон. Гэвч зарим аймагт бүсийг тогтоохдоо багийн нутгаар биш сумын нийт нутгаар авсанаас хамаарч нүүдлийн мал аж ахуйг өөр сум, багт шилжүүлэх боломжгүй болж хууль тогтоомж хэрэгжихэд хүндрэлтэй нөхцөл үүссэн байгааг шийдвэрлэх шаардлагатай байна.

6.2.Шинээр газар тариалан болон бусад суурин аж ахуй, уламжлалт нүүдлийн мал аж ахуй хоорондын хил заагийг тогтоох судалгаа хийх ажлын хүрээнд Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн Төрийн нарийн бичгийн даргын А-03 тоот тушаалаар ажлын хэсэг байгуулагдан ажиллаж байна.

6.3. Засгийн газрын 2019 оны 224 дүгээр тогтоолоор Дархан-Уул аймагт арьс ширний цогцолбор байгуулахаар шийдвэрлэж, ажлын явц 80%-тай байна. Дархан арьс ширний цогцолборын бүтээн байгуулалтыг эрчимжүүлэх, дэмжих чиглэлээр Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 118, 185, 234 дүгээр тогтоолууд батлагдан гарсан.

6.4. Улсын хэмжээнд 12 агропарк байгуулахаар төлөвлөснөөс Завхан аймгийн Тэс суманд малын тэжээлийн аж ахуй, Өвөрхангай аймгийн Хархорин суманд жимс, жимсгэнийн аж ахуй үйл ажиллагаагаа явуулж байна. Бусад агропарк байгуулах ажил ТЭЗҮ, хөрөнгө оруулалтын шатанд байгаа боловч хувийн хэвшлээс хамаарч бүтээн байгуулалт удаашралтай байна. Өмнөговь аймгийн 15 суманд 68 хүлэмж зээлээр олгож, хүлэмжийн тариалан эрхлэх нөхцлийг бүрдүүлсэн байна.

6.5. Дорнод, Сүхбаатар, Сэлэнгэ аймагт шар буурцаг, Дорнод, Сүхбаатар, Өвөрхангай, Баянхонгор, Ховд, Увс аймагт наранцэцэг, Хэнтий, Дорнод, Төв, Өвөрхангай, Архангай, Сэлэнгэ, Булган, Дархан-Уул, Хөвсгөл, Баянхонгор, Завхан, Говь-Алтай, Увс аймагт чихрийн манжинг тариалахад тохиромжтой газрын эрэл хайгуул, туршилт судалгаа хийх ажлын хувьд тодорхой ажил хийгдээгүй байна.

6.6. Хадлангийн газрын тодруулга судалгаа, нөөцөд авах хадлангийн газрын эрэл хайгуул хийх, газар зохион байгуулалтын төсөл боловсруулах, газрын кадастрын бүртгэлийн мэдээллийн сан үүсгэх ажлын хүрээнд улсын нийт хадлангийн 1.7 сая га талбайн 71 % нь зүүн 3 аймагт байгаа боловч тодруулга, судалгаа хийгдээгүй байна. 2021 онд Увс аймгийн 4 сумын хадлангийн талбайд хэмжилт хийж, 890 нэгж талбарын 9300 га хадлангийн талбайг кадастрын мэдээллийн санд бүртгэсэн бол бусад аймгийн хэмжээнд энэ ажил хийгдээгүй байна.

6.7. Улсын газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөнд 6 байршилд (Дорнод аймгийн Матад, Булган сум, Хэнтий, Сүхбаатар аймгийн Баян-Овоо, Түмэнцогт сум, Хөвсгөл аймгийн Цэцэрлэг сум, Архангай, Завхан аймгийн Цахир, Тосонцэнгэл, Их-Уул сум, Архангай, Баянхонгор, Өвөрхангай аймгийн Цэнхэр, Эрдэнэцогт, Бат-Өлзий сумд, Хэнтий аймгийн Өмнөдэлгэр, Хэрлэн, Биндэр сум) аймаг дундын отрын бүс нутгийг улсын тусгай хэрэгцээнд авахаар төлөвлөсөн.

Одоогоор 4 байршилд орон нутгийн тусгай хэрэгцээний сум дундын болон сумын отрын нөөц бэлчээр шинээр бий болгох боломжийн талаарх судалгаа хийж ажиллах тухай аймгийн засаг дарга, ХХААХҮ-ийн сайд нарын 2022 оны хамтын ажиллагааны гэрээнд тусган ажиллаж байна.

Хөвсгөл аймгийн Цэцэрлэг сумын нутагт отрын нөөц нутаг байгуулах ажлыг тус сумын ИТХ, багийн ИНХ дэмжээгүй тул цуцлагдсан бөгөөд 2021 онд Хөвсгөл аймгийн Алаг-Эрдэнэ, Эрдэнэбулган, Түнэл, Баянзүрх сумдын нутагт шинээр сум дундын отрын бүс байгуулах судалгаа хийгдэж, Алаг-Эрдэнэ, Баянзүрх сумын ИТХ-ын шийдвэрээр 40.6 мян.га талбайг сум дундын отрын нөөц бэлчээрээр батлаад байна.

Сүхбаатар аймгийн сумдад отрын нөөц бэлчээр бий болгох судалгааг 2020-2021 онд хийж, Мөнххаан, Наран, Сүхбаатар сумдын 153.25 мянган га бэлчээрийг орон нутгийн тусгай хэрэгцээний отрын нөөц нутаг болгон хил заагийг баталгаажуулж, хамгаалалтад авсан.

Хэнтий аймагт Хэрлэнбаян-Улааны аймаг дундын отрын бэлчээр байгаа тул шинээр отрын нөөц нутаг байгуулах боломжгүй гэсэн орон нутгийн санал ирээд байна.

Өвөрхангай аймгийн ИТХ-ын 2021 оны 05/05 тоот тогтоолоор нийт 14 сум дундын 626.31 мянган га бэлчээрийн орон нутгийн тусгай хэрэгцээний сум дундын отрын нөөц нутаг болгон хилийн зааг тогтоох, ашиглах журмыг шинэчлэн баталсан.

6.8. Хөдөө аж ахуйн "Халх гол" үндэсний бүтээн байгуулалтын бүсийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө, схем, ТЭЗҮ боловсруулах ажлын хүрээнд "Халх гол" үндэсний бүтээн байгуулалтын бүсийн хил заагт орсон улсын тусгай хамгаалалттай газар ("Ташгай таван нуур" БНГ) болон нөлөөлөлд өртөж буй иргэн, хуулийн этгээдийн газрыг улсын тусгай хэрэгцээний газраас хэсэгчлэн гаргах санал боловсруулж, холбогдох газруудаас санал авахаар бэлтгэл ажлыг хангаж байна. Цаашид "Халх гол" үндэсний бүтээн байгуулалтын ТЭЗҮ боловсруулах санхүүжилтийн асуудлыг шийдвэрлүүлэх шаардлагатай байна.

7. Хот тосгон, бусад суурин газрыг хөгжүүлэх зорилтын хэрэгжилт

Зорилтын хүрээнд нийт 7 арга хэмжээ 2020-2025 онд хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 1 арга хэмжээ 100%, 1 арга хэмжээ 80%, 4 арга хэмжээ 11-53%, 1 арга хэмжээ 0% хэрэгжилттэй байна.

7.1. Хот суурин газруудын тэлэлт, хөгжлийн хандлагыг харгалзан газар ашиглалтын тохиромжтой байдлын үнэлгээнд нийцүүлэн хот суурины эдэлбэр газрын хил заагийг шинэчлэн тогтоох аж ахуй хоорондын газар зохион байгуулалт хийх арга хэмжээг 2022 онд хэрэгжүүлэхээр төлөвлөж байна.

7.2. Их, дээд сургуулиудыг материаллаг бааз нөөц бүхий бүсүүдэд шилжүүлэх зорилгоор 8 байршилд шилжүүлэхээр төлөвлөсөн.

Засгийн газрын 2021 оны 321 дүгээр тогтоолоор Дархан-Уул аймаг дахь Хөдөө аж ахуйн их сургуулийн харьяа Ургамал газар тариалангийн хүрээлэнгийн Агро-Экологи, бизнесийн сургуулийг хөдөө аж ахуй, газар тариалангийн чиглэлээр төрөлжүүлэх, Өмнөговь аймагт эрчим хүч, геологи, уул уурхай, барилга, мэдээллийн технологийн чиглэлээр Шинжлэх ухаан, технологийн их сургуулийн харьяа сургуулийг шинээр байгуулах, Орхон аймаг дахь Шинжлэх ухаан, технологийн их сургуулийн харьяа "Эрдэнэт цогцолбор" дээд сургуулийг уул уурхай, технологийн чиглэлээр төрөлжүүлэн хөгжүүлэхээр шийдвэрлэлээ.

Хөдөө, аж ахуй, хүнс, биотехнологийн салбар сургууль, байгууллагуудыг шилжүүлэх ажлын хүрээнд Зүүн бүсийн сургалт, эрдэм шинжилгээ, үйлдвэрлэл, бизнесийн төвийг Дорнод аймгийн Чойбалсан хотод 30 га газарт байгуулахаар төлөвлөсөн.

Байгаль орчин, экологийн боловсролын салбар сургууль, байгууллагуудыг шилжүүлэх ажлын хүрээнд Баруун бүсийн сургалт, эрдэм шинжилгээ, үйлдвэрлэл, бизнесийн төвийг Ховд аймагт 200 га газарт байгуулахаар төлөвлөсөн.

Нийслэлийн Багануур дүүрэгт их, дээд сургуулиудын хотхон байгуулах ажлын хүрээнд "Шинжлэх ухаан, үйлдвэр, технологийн цогцолбор"-ыг 10000 га газарт байгуулахаар төлөвлөж, Их сургуулиудын хотхоны ерөнхий төлөвлөгөөг баталсан.

Цаашид Машин механизм, металлургийн салбар сургууль шилжүүлэх, Боловсролын салбарын сургууль, байгууллага шилжүүлэх, Батлан хамгаалах чиглэлийн боловсон хүчин бэлтгэх сургууль шилжүүлэх чиглэлээр тодорхой арга хэмжээ авах шаардлагатай байна.

7.3. Улсын хэмжээнд 24 барилгын материалын үйлдвэрийг байгуулахаар төлөвлөснөөс Баян-Өлгий, Ховд аймагт бетон зуурмагийн үйлдвэр, Налайх дүүрэгт ширэм болон ган цутгамлын үйлдвэр, арматурын 2 үйлдвэр, Архангай аймагт чулуу бутлан ангилах үйлдвэр, Дорнод аймагт бетон зуурмаг, темер бетон дэрний үйлдвэр ажиллаж байна. Дархан-Уул аймагт бетон зуурмагийн 2 үйлдвэр зогссон байна.

7.4. Эмээлт, Налайх, Багануурт байгуулах үйлдвэрлэл, технологийн паркуудыг бүрэн ашиглалтад оруулах арга хэмжээний хүрээнд Эмээлтийн хөнгөн үйлдвэрийн Үйлдвэрлэл, технологийн паркуудыг бүрэн ашиглалтад оруулах зорилтын хүрээнд дараах ажлууд хийгдсэн байна. Үүнд:

- Эмээлтийн хөнгөн үйлдвэрийн үйлдвэрлэл, технологийн парк 2014 онд байгуулагдсан бөгөөд ТЭЗҮ, ХЕТ хийгдсэн. Мөн цахилгаан хангамжийн дэд станц, цахилгаан дамжуулах агаарын шугмын зураг төсөл, үерийн болон ундны усны хангамжийн барилгын зураг төсөл, паркийн дэд бүтцийн инженерийн шугам сүлжээний ажлын зураг төсөл, авто замын ажлын зураг төсөл хийгдэж байна. Паркийн хөгжлийн төлөвлөгөө, паркад байрлах үйлдвэрүүдэд тавигдах шаардлагыг боловсруулсан. Монгол Улсын Ерөнхий сайдын 2017 оны 11 дүгээр сарын 29-ний өдрийн 173 дугаар захирамжаар Эмээлт парк төслийн ажлыг эрчимжүүлэх, дэд бүтцийн бүтээн байгуулалтын санхүүжилтийг шийдвэрлэх арга замыг судалж танилцуулах үүрэг бүхий ажлыг хэсэг байгуулагдан ажиллаж байна.

-Налайхын барилгын материалын үйлдвэрлэл, технологийн парк 2014 онд байгуулагдсан бөгөөд 120 га газарт ТЭЗҮ, ХЕТ, БОННУ хийгдсэн. Цаашид 130 га газарт өргөтгөхөөр төлөвлөж байна. Одоогоо авто зам, паркийн оффис, цахилгааны дэд станц, 2 гүний худаг, үерийн байгууламж баригдаад байна. Одоогоор 2 аж ахуйн нэгж үйл ажиллагааг эхэлсэн байна. Цаашид цахилгаан хангамж, дулаан хангамж, усан хангамж, цэвэрлэх байгууламж, шилэн кабель, авто зам, төмөр зам, инженерийн сүлжээ, ус дамжуулах төвийн барилгын ажлууд хүлээгдэж байна.

-Багануур Үйлдвэрлэл, Технологийн Парк 2015 онд байгуулагдсан бөгөөд 2021 онд паркийн гадна инженерийн шугам сүлжээний зураг төсөл, дэд станцын зураг төсөл хийгдсэн.

7.5. Хүнд аж үйлдвэрийн 4 үйлдвэрийн ТЭЗҮ боловсруулах ажлын хүрээнд мини домен зуух бүхий гангийн үйлдвэр, зэсийн баяжмал боловсруулах үйлдвэр, газрын тос боловсруулах үйлдвэр, нүүрснээс нийлэг байгалийн хий үйлдвэрлэх үйлдвэрийн ТЭЗҮ-г тус тус баталсан байна. Газрын тос боловсруулах үйлдвэрийн бүтээн байгуулалтын ажил эхэлсэн бол бусад үйлдвэрийн барилгын ажил эхлээгүй байна.

7.6. Улсын хэмжээнд 143 хөнгөн үйлдвэр байгуулахаас 64 үйлдвэр байгуулагдаж, 24 үйлдвэр ТЭЗҮ боловсруулах, хөрөнгө оруулалт татах шатанд байна. Үлдсэн 55 үйлдвэр байгуулагдаагүй байна.

7.7. Геронтологийн үндэсний төв, Зоонозын өвчин судлалын үндэсний төв, Сүрьеэгийн эмнэлэг барих барилгын ажлын явц удаашралтай байгааг анхаарч ажиллах шаардлагатай байна.

Хот суурин газруудын тэлэлт, хөгжлийн хандлагыг харгалзан газар ашиглалтын тохиромжтой байдлын үнэлгээнд нийцүүлэн хот суурины эдэлбэр газрын хил заагийг шинэчлэн тогтоох аж ахуй хоорондын газар зохион байгуулалт хийх арга хэмжээг хэрэгжүүлэхээр Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газрын 2022 оны ажлын төлөвлөгөөнд тусгаад байна.

8. Ойн сан бүхий газрын төлөвлөлт, хэрэгжилт

Зорилтын хүрээнд нийт 7 арга хэмжээ 2020-2025 онд хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 2 арга хэмжээ 100%, 2 арга хэмжээ 10%, 1 арга хэмжээ 30%, 2 арга хэмжээ 0%-ийн хэрэгжилттэй байна.

8.1. Баянхонгор, Булган, Говь-Алтай, Завхан, Орхон, Өвөрхангай, Өмнөговь, Сэлэнгэ, Хэнтий аймагт улс болон орон нутгийн төсвийн хөрөнгөөр 2967 га талбайд ойжуулалтын ажлыг хийж гүйцэтгэсэн.

8.2. Баянхонгор аймгийн төв, Говь-Алтай аймгийн төв, Дорноговь аймгийн төв, Өмнөговь аймгийн төв, Дундговь аймгийн Эрдэнэдалай, Цагаандэлгэр, Дэрэн, Гурвансайхан, Говь-Угтаал сумдад, Завхан аймгийн Тэлмэн, Завханмандал, Отгон сумдад суурин газрын хамгаалалтын ойн зурвас байгуулсан бол улс болон орон нутгийн төсвийн хөрөнгөөр 310 га талбайд хамгаалалтын ойн зурвас байгуулсан.

8.3. Улсын газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөнд тариалан бүхий аймгуудад тариалангийн газрын ойн зурвас байгуулахаар төлөвлөсөн. 2021 онд Өмнөговь аймгийн хэмжээнд Гурвантэс, Ноён, Цогт-Овоо сумдын хүнсий ногооны 2.17 га талбайд ойн хамгаалалтын зурвасыг байгуулсан.

8.4. Улсын хэмжээнд 1334 ойн нөхөрлөл 4.5 сая га, 90 аж ахуйн нэгж 770.0 мян.га, нийт 5.3 сая.га ойн сангийн талбайг эзэмшиж, ашиглаж, хамгаалах үйл ажиллагааг хэрэгжүүлж байна.

8.5. Өмнөговь, Баянхонгор аймгууд ойн сан бүхий газартаа ойн менежментийн төлөвлөгөөгөө батлуулсан байна.

8.6. Говь, хээрийн нөхцөлд тохиромжтой ойн таримлын үр, суулгац үржүүлэх чиглэлээр шинжлэх ухаан, туршилт, судалгааны нэгжийг Увс аймгийн Тариалан, Дорнод аймгийн Халхгол, Өмнөговь аймгийн Ханбогдод байгуулахаар төлөвлөсөн. Улсын хэмжээнд нийт 875.8 га талбайд 225 мод үржүүлгийн газар үйл ажиллагаа явуулж, 42 сая ширхэг тарьц суулгацыг ургуулж байна.

Цаашид ойжуулах тохиромжтой байдлын үнэлгээнд нийцүүлэн сонгосон газарт эхний ээлжинд ойжуулалтыг хийх, суурин газрын болон тариалангийн талбайн ойн зурвас байгуулах ажлыг төлөвлөгөөнд тусгагдсан байршилд хэрэгжүүлэх шаардлагатай байна.

8.Зам, шугам сүлжээний газрын төлөвлөлт, хэрэгжилт

Зорилтын хүрээнд нийт 6 арга хэмжээ 2020-2025 онд хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 2 арга хэмжээ 100%, 1 арга хэмжээ 50%, 2 арга хэмжээ 25-30%, 1 арга хэмжээ 10%-ийн хэрэгжилттэй байна.

8.1.Төлөвлөгөөгөөр нийт 108 чиглэлд хатуу хучилттай автозам барихаас 7 чиглэлийн зам дуусаж, 8 чиглэлийн зам барих ажил 10-85% хэрэгжилттэй байна.

Дараах 7 чиглэлийн автозам ашиглалтад орсон. Үүнд:

1. Улаанбаатар-Хөшигтийн хөндий чиглэлийн 23 км авто зам;
2. Улаанбаатар-Даланзадгад-Цогтцэций чиглэлийн 55 км авто зам;
3. Зүүнбаян-Хамрын хийд чиглэлийн 20 км авто зам;
4. Алтай-Ховд чиглэлийн 8 км авто зам;
5. Оюу толгой-Ханбогд чиглэлийн 36 км авто зам;
6. Цант-Цогтцэций Гашуунсухайтын зам чиглэлийн авто зам;
7. Хүдэр-Ерөө чиглэлийн 95 км авто зам.

Дараах 8 чиглэлийн автозам 10-85% хэрэгжилттэй байна. Үүнд:

1. Даланжаргалан-Бор-Өндөр чиглэлийн 45.51 км авто зам 85%;
2. Өмнөговь. Даланзадгад-Шивээхүрэн боомт чиглэлийн 271 км авто зам 30%;
3. Өндөрхаан-Бэрх-Дадал чиглэлийн 272 км авто зам 35%;
4. Өндөрхаан-Ульхан боомт чиглэлийн 72 км авто зам 50%;
5. Шаамар-Зэлтэрийн боомт чиглэлийн 112 км авто зам 17%;
6. Улиастай-Ховд чиглэлийн 381 км авто зам 20%;
7. Өгийнуур-Их тамир чиглэлийн 103 км авто зам 40%;
8. Архангай аймгийн Цэцэрлэг-Шивэрт чиглэлийн 23 км авто зам 15%.

8.2. Нийт 24 чиглэлд төмөр зам барихаар төлөвлөснөөс 2 төмөр зам баригдаж, 4 чиглэлийн төмөр замын ТЭЗҮ батлагдаж, 12 чиглэлийн төмөр замын ТЭЗҮ-г боловсруулж, 6 чиглэлийн төмөр замын ТЭЗҮ-г боловсруулж эхлээгүй байна.

Дараах чиглэлийн төмөр зам баригдсан. Үүнд:

1. Сэлэнгэ аймгийн Ерөө сум Хандгайт өртөө-Төмөртэйн уурхай чиглэлийн төмөр зам;

2. Дорноговь аймгийн Алтанширээ суманд байгуулах газрын тос боловсруулах үйлдвэрийн төмөр зам /Сайншанд сумаас/.

Дараах чиглэлийн төмөр замын ТЭЗҮ-ийг баталсан. Үүнд:

1. Өмнөговь аймгийн Цогтцэций сум, Таван толгой уурхайгаас-Дорноговь аймгийн Сайншанд;
2. Өмнөговь аймгийн Цогтцэций сум Ухаа худаг-Өмнөговь аймгийн Ханбогд сум, Гашуун сухайт боомт чиглэлийн төмөр зам;
3. “Богд хаан” төмөр зам /Рашаант-Мааньт өртөө/ чиглэлийн төмөр зам;
4. Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр зам.

8.3.Авто тээврийн үйлчилгээний цогцолборыг 20 байршилд төлөвлөснөөс 6 буюу Архангай аймгийн Эрдэнэбулган, Төв аймгийн Баян, Баянхонгор аймгийн Баянхонгор сум, Булган аймгийн Рашаант сум, Нийслэлийн Багануур дүүрэг, Ховд аймгийн Дарви сумдад авто тээврийн үйлчилгээний цогцолбор баригдаад байна.

8.4.Дорноговь аймгийн Замын-Үүд суманд 400 га газрыг улсын тусгай хэрэгцээнд авсан бөгөөд логистикийн үйл ажиллагааг эхлүүлээд байна. Төв аймгийн Хөшигийн хөндийн ложистикийн төв судалгаа, төлөвлөлтийн шатанд байна.

8.5.Төв болон орон нутгийн аэродромын аюулгүйн бүсийг дахин төлөвлөх ажлын хүрээнд 17 нисэх буудлын аэродромын аюулгүй бүсүүдийг тогтоосон.

Энэ зорилтын хүрээнд авто болон төмөр зам барих, авто тээврийн үйлчилгээний цогцолбор байгуулах, тээвэр ложистикийн төвүүдийг шинээр төлөвлөх ажлын хэрэгжилт 10-30% хэрэгжилттэй байна.

9.Дэд бүтцийн салбарыг хөгжүүлэх зорилтын хэрэгжилт

Зорилтын хүрээнд нийт 10 арга хэмжээ 2019-2025 онд хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 3 арга хэмжээ 100%, 1 арга хэмжээ 80%, 5 арга хэмжээ 15-40%, 1 арга хэмжээ 10%-ийн хэрэгжилттэй байна.

9.1.Дорноговь аймгийн Сайншанд суманд 30 МВт, Говьсүмбэр аймгийн Сүмбэр суманд 15 МВт-ын нарны цахилгаан станц ашиглалтад орсон. Ховд аймгийн Мянгад суманд 10 МВт, Говь-Алтай аймгийн Есөнбулаг суманд 10МВт нарны, Алтай суманд нар-салхи-цэнэг хураагуурын хосолсон системийн ТЭЗҮ боловсруулан баталж, барих ажлыг эхлээд байна. Хөвсгөл аймгийн Ханх суманд салхин цахилгаан станцын ТЭЗҮ боловсруулах, барих ажлыг эхлүүлэх шаардлагатай байна.

9.2.Шүрэнгийн, Эгийн, Чаргайт, Ховд, Баглах УЦС-ын ТЭЗҮ-ийг ЭХЯ-ны ШУТЗ-ийн хэлэлцэж дэмжээд байна. Эрдэнэбүрэнгийн УЦС-ыг барих барилгын ажлыг 2022 оны эхлэхээр төлөвлөж байна. Орхон, Туул голын усан цахилгаан станцуудыг байгуулах судалгааны ажлыг хийх шаардлагатай байна.

9.3.Төлөвлөгөөнд тусгагдсанаар 18 чиглэлд цахилгаан дамжуулах агаарын шугам барихаас 2 чиглэл буюу Тавантолгой-Оюутолгойг холбосон 2 хэлхээт 220кВ-ын 138 км цахилгаан дамжуулах шугам, Эрдэнцагаан Баруун-Урт чиглэлийн 35кВ-ын цахилгаан дамжуулах шугам ашиглалтад орж, 5 шугамын чигийг батлаад байна. Цаашид 12 чиглэлд ТЭЗҮ хийх шаардлагатай байна.

9.4.Төлөвлөгөөнд тусгагдсанаар 7 дулаан цахилгаан станц барихаас Тэвшийн говийн нүүрсний уурхай- 600 МВт, Багануурын 700 МВт, Хөшөөтийн нүүрсний уурхай ДЦС, Тавантолгойн ДЦС 700 МВт, Хөшөөтийн нүүрсний уурхай 50 МВт-ын 5 станцын ТЭЗҮ-г боловсруулж, Шивээ-Овоогийн нүүрсний уурхайн ДЦС-ын ТЭЗҮ боловсруулах шатанд байна.

9.5. Улсын хэмжээнд 21 аймгийн төв, 330 суманд өндөр хурдны өргөн зурвасын сүлжээний хурдны техникийн шинэчлэл хийж, үе шаттай нэмэхээр төлөвлөж байна. Хэнтий аймгийн Өмнөдэлгэр сумын Гурванбаян баг /55 км/, Хэнтий аймгийн

Дэлгэрхаан сумын Хэрлэнбаян-Улаан баг /38 км/, Булган аймгийн Хангал сумын Хялганат баг /30 км/, Архангай аймгийн Хашаат сум /45км/ төвийг өндөр хурдны шилэн кабелийн сүлжээнд холбосон.

9.6.Монгол Улсын нутаг дэвсгэрийг бүрэн хамарсан радио өргөн нэвтрүүлгийн тоон сүлжээг бий болгох ТЭЗҮ боловсруулсан боловч энэ ажлын зардлыг 2021 оны улсын төсөвт тусгагдаагүй тул хэрэгжээгүй байна.

9.7. Улаанбаатар хотыг метан хийгээр хангах инженерийн байгууламж, дэд бүтцийг цогцоор нь барьж байгуулах ажлын хэрэгжилт 10 хувийн хэрэгжилттэй байна.

Энэ зорилтын хүрээнд цахилгаан дамжуулах агаарын шугам барих, дулааны цахилгаан станц барих, Монгол Улсын нутаг дэвсгэрийг бүрэн хамарсан радио өргөн нэвтрүүлгийн тоон сүлжээг бий болгох ажлын хэрэгжилт 10-40%-ийн хэрэгжилттэй байгааг анхаарч ажиллах шаардлагатай байна.

10.Улсын тусгай хэрэгцээний газрын төлөвлөлтийн хэрэгжилт

Зорилтын хүрээнд нийт 6 арга хэмжээ 2019-2025 онд хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 3 арга хэмжээ 50%, 1 арга хэмжээ 35%, 1 арга хэмжээ 20%, 1 арга хэмжээ 0%-ийн хэрэгжилттэй байна.

10.1.Төлөвлөгөөнд тусгагдснаар нийт 130 газрыг улсын тусгай хамгаалалтад авахаар төлөвлөснөөс УИХ-ын 2019 оны 41 дүгээр тогтоолоор 17 газрыг улсын тусгай хамгаалалтад аваад байна.

2021 онд 13 газрыг тусгай хамгаалалтад авах судалгааны ажлыг хийсэн бол 3 газрыг тусгай хамгаалалтад авах асуудлыг Засгийн газрын хурлаар хэлэлцүүлэхэд бэлтгэж байна. Мөн онд улсын тусгай хамгаалалтад авахаар төлөвлөсөн 14 газарт ашиглалтын 1 лицензийн 1980 га талбай, хайгуулын 3 лицензийн 13997 га талбай тус тус давхцалтай байна.

Цаашид гол мөрний урсац бүрэлдэх эхэд ашиглалтын 33 лицензийн 9311 га талбай, хайгуулын 9 лицензийн 5628 га талбай, усны сан бүхий газрын хамгаалалтын бүсэд ашиглалтын 273 лицензийн 18506 га талбай, хайгуулын 93 лицензийн 6433 га талбай тус тус давхцалтай байгааг арилгах шаардлагатай.

10.2.Түүх, соёлын өвийг хамгаалалтад авах чиглэлээр дараах 2711 дурсгалд хамгаалалтын зэрэглэл тогтоосон боловч хамгаалалтад авах талаар тодорхой ажил хийгдээгүй байна. Үүнд:

- Улсын тусгай хамгаалалтад авах 182 дурсгал;
- Аймаг, нийслэлийн хамгаалалтад байх 607 дурсгал;
- Сум, дүүргийн хамгаалалтад байх 1919 дурсгал.

10.3.2021 онд Баянхонгор аймагт 3, Говьсүмбэр аймагт 62, Өвөрхангай аймагт 24 байршилд түүх соёлын дурсгалт зүйл байгааг тогтоож, тухайн аймгийн Засаг даргын захирамжаар хамгаалалтад аваад байна.

10.4.УГЗБЕТ-нд тусгагдсан 12 сумаас Говь-алтай аймгийн Эрдэнэ сумын нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөөг баталсан байна. Үлдсэн 11 сумын төлөвлөгөөг одоогоор боловсруулаагүй байна.

10.5.Нийслэлийн Засаг даргын 2021 оны А/124 дүгээр захирамжаар Америкийн Нэгдсэн Улсын дипломат төлөөлөгчийн газрын зориулалтаар, Арабын Нэгдсэн Эмират Улсын дипломат төлөөлөгчийн газрын зориулалтаар тус тус 60 жилийн хугацаатайгаар ашиглуулах эрх олгосон.

10.6.Төв аймгийн Хөшигийн хөндийн нисэх буудалд эдийн засгийн чөлөөт бүс байгуулах ажил эхлэлийн шатанд байгаа бол Эрдэнэт, Дарханы төмөрлөгийн

үйлдвэрийг чиг үүргийн хандлагаар аж үйлдвэрийн өндөр технологийн чөлөөт бүс болгох ажил хэрэгжээгүй байна.

10.7.Одоо байгаа Замын-Үүд, Алтанбулаг, Цагааннуурын чөлөөт бүсийн хэмжээнд газрын кадастрын бүртгэлийн програмыг нэвтрүүлсэн.

Замын-Үүд чөлөөт бүсэд 48 га талбайд шинээр автозам, холбоо дохиолол, усан хангамж, ариутгах татуурга, цахилгаан хангамж, дулааны станцын барилга байгууламж барьсан. Чөлөөт бүсийн шинэ мастер төлөвлөгөөний дагуу 68 хөрөнгө оруулагчид 101 га талбайг сонгон шалгаруулалтаар эзэмшүүлээд байгаагийн 7 га талбайд аялал жуулчлал, 47 га талбайд үйлдвэрлэл, 20 га талбайд худалдаа, үйлчилгээ, 25 га талбайд агуулах, ложистик, 1.4 га талбайд шатахуун түгээх станцын зориулалтаар ашиглаж байна.

Алтанбулаг чөлөөт бүсийн хувьд цахилгаан хангамж, гадна, доторх цэвэр, бохир усны шугам хоолой, үерийн хамгаалалтын далан суваг, сайжруулсан шороон автозамын дэд бүтцийн ажил хийгдсэн. Одоогоор 25 аж ахуйн нэгж үйл ажиллагаагаа эхэлсэн байна.

Цагааннуур чөлөөт бүсийн хувьд бэлтгэл ажил хийгдэж, чөлөөт бүсийн үйл ажиллагааг эхлүүлэх асуудлаар Засгийн газрын хуралдаанд танилцуулахаар төлөвлөж байна.

“Алтанбулаг”, “Цагааннуур” чөлөөт бүсийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөө боловсруулах ажил хийгдэж байна.

Энэ зорилтын хүрээнд улсын тусгай хэрэгцээний газартай холбогдох төсөл, арга хэмжээг зохион байгуулах арга хэмжээний хүрээнд соёлын өв, түүхийн дурсгалуудын хамгаалалтын бүсийг газар дээр нарийвчлан тогтоох, бүртгэлжүүлэх, сумын нийт нутаг дэвсгэрийн 70-аас дээш хувь нь улсын тусгай хамгаалалттай газар нутгийн сүлжээнд хамрагдсан 12 сумын нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөө боловсруулах, аюултай хог хаягдлын байгууламж барих газрыг улсын тусгай хэрэгцээнд авах, отрын болон улсын тэжээлийн сангийн хадлангийн талбайн байршил, хил заагийг тодруулах, гол, мөрний урсац бүрэлдэх эх, усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий газарт ашигт малтмал хайх, ашиглахыг хориглох тухай хуулийн хүрээнд авч хэрэгжүүлэх арга хэмжээ, түүх соёлын дурсгалт газрыг түшиглэн аялал жуулчлалыг хөгжүүлэх, рашаан сувиллын аялал жуулчлалыг хөгжүүлэх чиглэлээрх арга хэмжээг хэрэгжүүлэхэд анхаарч ажиллах шаардлагатай.

ДӨРӨВ. ДҮГНЭЛТ

• 2021 оны байдлаар улсын газар зохион байгуулалтын төлөвлөгөөний хэрэгжилтийг дүгнэхэд 43.0 хувийн биелэлттэй байна.

Улсын газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөний зорилт арга хэмжээ /2021 оны байдлаар/

№	Зорилт	Арга хэмжээний тоо	Хэрэгжилт, %
1	Газрын нөөц, нэгдмэл сангийн удирдлага, бодлого, төлөвлөлт, хууль, эрх зүйн орчныг боловсронгуй болгох	6	65.0
2	Хүн амыг баталгаат, эрүүл аюулгүй усаар хангах	6	44.6
3	Хөдөө аж ахуйн салбарыг хэрэгцээт усаар хангах	6	50.0

4	Үйлдвэр, уул уурхай, эрчим хүчний салбарыг хэрэгцээт усаар хангах	8	66.5
5	Хүрээлэн буй орчны тэнцвэрт байдлыг хангах, усны нөөцийг хамгаалах	8	36.3
6	Хөдөө аж ахуйн салбарыг хөгжүүлэх	12	18.3
7	Хот тосгон, бусад суурин газрыг хөгжүүлэх	18	35.8
8	Ойн сан бүхий газрын төлөвлөлт, хэрэгжилт	7	35.7
9	Зам, шугам сүлжээний газрын төлөвлөлт, хэрэгжилт	6	42.6
10	Дэд бүтцийн салбарыг хөгжүүлэх	10	43.3
11	Улсын тусгай хэрэгцээний газрын төлөвлөлт, хэрэгжилт	11	35.5
	НИЙТ	98	43.0

- Цаашид төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээг хэрэгжүүлэх чиглэлээр хэрэгжүүлэгч байгууллагууд хамтран ажиллах, төсөв хөрөнгөөс хамаарахгүй ажлуудыг цаг алдалгүй хэрэгжүүлэхэд анхаарч ажиллах шаардлагатай байна.

ТАВ. ЦААШИД АВАХ АРГА ХЭМЖЭЭ

Цаашид дараах чиглэлд анхаарч ажиллах шаардлагатай байна. Үүнд:

- Төлөвлөгөөнд заасан шалгуур үзүүлэлт, хүрэх түвшинтэй нийцүүлэн тайлагнаж байх (ям, агентлаг, аймгийн ГХБХБГ)
- Архангай, Говь-алтай, Ховд аймгийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөг шинэчлэх ажлыг 2022 онд багтаан зохион байгуулах (Архангай, Говь-алтай, Ховд аймгийн Засаг дарга)
- Хөв цөөрөм байгуулах, худаг гаргах газрын байршлыг тодорхойлох чиглэлээр Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам, Усны газар, Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газар хамтран ажиллах (ХХААХҮЯ, Усны газар, Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газар)
- Газрын тухай хуулийн 12 дугаар зүйлд заасны дагуу сумын төв, тосгон, суурин газрын суурьшлийн тэг гортигийг шинэчлэх талаар судалгаа хийх (Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газар, аймгийн ГХБХБГ)
- Гол, мөрний урсац бүрэлдэх эх, усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий газарт ашигт малтмал хайх, ашиглахыг хориглох тухай хуулийн 4.1-д заасны дагуу гол, мөрний урсац бүрэлдэх эх орчмын газартай давхцалтай ашиглалтын 33 лицензийн 9311 га талбай, хайгуулын 9 лицензийн 5628 га талбай, улсын тусгай хамгаалалтад авахаар төлөвлөсөн 14 газартай давхцалтай ашиглалтын 1 лицензийн 1980 га талбай, хайгуулын 3 лицензийн 13997 га талбайн давхцлыг арилгах (БОАЖЯ, УУХҮЯ)

БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН ЯАМ

ГАЗАР ЗОХИОН БАЙГУУЛАЛТ, ГЕОДЕЗИ, ЗУРАГ ЗҮЙН ГАЗАР